

20 Бурханы Хурга

20.1 Үнэн

³⁷Пилат Түүнд -Тэгэхлээр Та Хаан байх нь ээ? гэхэд Есүс - Намайг Хаан гэж та хэлж байна. Учир нь Би үнэний тухай гэрчлэхээр төрсөн бөгөөд үүний тулд л ертөнцөд ирсэн. Үнэний хүн бүр Миний дууг сонсоно гэж айлдлаа (Иохан 18:37 АБ 2004)

[] Та Есүсийн дуу хоолойг сонсдог уу?

20.2 Миний мах, цус нь ертөнцийн гэм нүглийн төлөө

⁴⁴Намайг илгээсэн Эцэг хэн нэгнийг татахгүй л бол хэн ч Над уруу ирж чадахгүй. Би тэр хүнийг эцсийн өдөрт амилуулна. ⁴⁵“Тэд бүгд Бурханаар сургагдах болно” гэж эш үзүүлэгчдийн номд бичигджээ.

Эцэгээс сонсож, сурсан хүн бүр Над уруу ирдэг. ⁴⁶Бурханаас ирсэн Нэгэнээс өөр хэн ч Эцэгийг хараагүй бөгөөд Тэр л Эцэгийг харсан юм.

⁴⁷Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Итгэдэг хүн мөнх амьтай. ⁴⁸Би бол амийн талх байна. ⁴⁹Та нарын өвөг дээдэс цөлд манна идсэн бөгөөд тэд нас барцгаасан. ⁵⁰Энэ нь тэнгэрээс бууж ирэх талх бөгөөд үүнээс идэгч нь үхэхгүй. ⁵¹Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна.

Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм гэж айлдлаа. ⁵²Тэгтэл иудейчүүд хоорондоо -Энэ хүн Өөрийнхөө махан биеийг бидэнд идүүлэхээр яаж өгч чадах юм бэ? гээд л маргалдаж эхлэв. ⁵³Есүс тэдэнд -Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй.

⁵⁴Миний махыг идэж, цусыг уусан хүн мөнх амьтай бөгөөд Би түүнийг эцсийн өдөрт амилуулна. ⁵⁵Учир нь Миний мах бол жинхэнэ хоол, Миний цус бол жинхэнэ ундаа мөн. ⁵⁶Миний махыг идэж, цусыг уусан хүн Миний дотор

байж, Би ч түүний дотор оршин байна. ⁵⁷Амьд Эцэг маань Намайг илгээсэн бөгөөд Би Эцэгээр амьдрахын адил Намайг идэгч хүн мөн Надаар амьдарна.

⁵⁸Тэнгэрээс бууж ирсэн талх бол энэ мөн. Гэхдээ та нарын өвөг дээдэс идсэн, нас барсантай нь адилгүй, энэ талхыг идсэн хүн мөнхөд амьдарна гэлээ. ⁵⁹Есүс Капернаумын синагогт заахдаа энэ бүхнийг айлджээ. (Иохан 6:44-59 АБ 2004)

[] Та Бурханаас суралцдаг уу?

[] Та нар өдөр бүр ууж, иддэг үү?

Есүсийн туулсан сорилтыг дүгнэн, тэдгээр сорилтыг өөрийнхтэйгөө харьцуулаарай. Тэр үхлийн хүчийг ялан дийлж, сүмийг төрүүлсэн. Та Христийн төлөө эсвэл бусдын төлөө сорилтыг даван туулж байна уу?

20.3 Дуулал 22:1-21

• Гутамшигт үхлээр үхэх

¹Бурхан минь, Бурхан минь, юунд Та намайг орхисон бэ? Миний ёлох дуу, миний авралаас Та юунд хол байна вэ?

²Бурхан минь ээ, би өдөр хашхирдаг боловч Та хариулдаггүй. Шөнө ч бас хашхирдаг боловч надад хариу үгүй. ³Гэвч Израилийн магтаал дунд сэнтийд залрагч аа, Та бол ариун юм. ⁴Бидний эцэг өвгөд Танд итгэсэн. Тэд итгэсэн бөгөөд Та тэднийг аварсан. ⁵Тэд Тан уруу хашхирч, аврагдаж байв. Тэд Танд итгэсэн бөгөөд ичгүүрт унасангүй.

⁶Харин би бол өт, хүн биш! Би бол хүмүүсийн буруутгал бөгөөд ард олонд жигшигдсэн юм. ⁷Намайг хардаг бүхэн намайг тохуурхан инээдэг. Тэд уруулаа нээж, толгой сэгсрэн ⁸“Тэр өөрийгөө ЭЗЭНд даатгасан. Тэр түүнийг авраг! Тэр түүнд баярладаг тул түүнийг авраг!” гэж байна.

⁹Гэсэн ч Та бол намайг эхийн хэвлийгээс гаргасан Тэр мөн. Эхийнхээ хөхөөр байх үед Та намайг итгүүлсэн. ¹⁰Би төрөхөөсөө Танд даатгагдсан. Эхийнхээ хэвлийд байх үеэс минь Та миний Бурхан байсан.

¹¹Зовлон ойрхон байгаа учраас Надаас бүү холдооч. Учир нь туслах хүн нэг ч алга. ¹²Олон үхэр намайг хүрээлсэн. Башаны хүчтэнүүд намайг бүсэлсэн. ¹³Хуу татахаар архиран байгаа арслан шиг Тэд над уруу амаа том ангайлгадаг. ¹⁴Намайг ус шиг асгасан бөгөөд Миний бүх яс мултарсан. Миний зүрх лааны тос адил юм. Тэр нь миний дотор хайлсан. ¹⁵Миний хүч шаазангийн хэлтэрхий шиг хатаж, Миний хэл түүшиндээ наалдсан. Та намайг үхлийн шороонд тавьдаг. ¹⁶Учир нь намайг ноход хүрээлжээ. Бүлэг хорон санаатнууд намайг бүсэлжээ. Тэд миний гар, хөлийг нэвт хатгасан.

¹⁷Би бүх ясаа тоолж чадна. Тэд харж, над уруу гөлрөн ширтдэг. ¹⁸Тэд миний гадуур хувцсыг хоорондоо хувааж, Миний дотуур хувцасны төлөө шоддог.

¹⁹Харин, ЭЗЭН, Та бүү холдооч. Миний хүч чадал аа, надад туслахаар хурдлаач. ²⁰Миний сэтгэлийг илднээс, Миний ганц амийг нохойн эрхшээлээс авраач. ²¹Намайг арслангийн амнаас авраач. Зэрлэг үхрийн эврээс аварч, Надад хариу өгөөч. (Дуулал 22:1-21 АБ 2004)

20.4 Мессиагийн зовлонт үхэл

³⁰тэд -Хэрэв энэ Хүн бузрыг үйлдээгүйсэн бол, бид Түүнийг танд тушаахгүй л байх байсан гэлээ. ³¹Тэгтэл Пилат -Түүнийг та нар ав. Өөрсдийнхөө хуулиар Түүнийг шүүгтүн гэхэд иудейчүүд -Хүн цаазлахыг бидэнд зөвшөөрдөггүй шүү дээ гэгцгээв. ³²Ямар үхлээр үхэхээ хэлж байсан Есүсийн үг биелэгдэхийн тулд тийн хэлжээ. (Иохан 18:30-32 АБ 2004)

[] Та шинэ амьдралдаа яах ёстойгоо мэдэх үү?

20.5 Найзын урвалт

⁹Миний итгэдэг, Миний талхыг идэж байсан дотно найз минь ч Миний эсрэг өсгийгөө өргөсөн.(Дуулал 41:9 АБ 2004)

³Арван хоёрын нэг болох Искарриот гэгддэг Иудагт Сатан шүглэв. ⁴Тэр явж, Есүсийг яаж бариулах талаар ахлах тахилч нар болоод түшмэдтэй зөвлөлдөв. (Лук 22:3:4 АБ 2004)

¹⁸Би та нарын бүгдийн чинь тухай яриагүй. Сонгосон нэгнээ Би мэднэ. Харин энэ нь “Миний талхыг идэгч нь Миний эсрэг өсгийгөө өргөв” гэж бичигдсэн Судрыг биелүүлэхийн тулд юм (Иохан 13:18 АБ 2004)

20.6 Үгүйсгэгдсэн, үл тоомсорлогдсон

¹⁰Гэвч Түүнийг няцалж, өвтгөх нь ЭЗЭНий таалал байв. Хэрэв Тэр Өөрийгөө нүглийн төлөөх тахил болгон өргөвөл, Тэр үр удмаа үзэж, Өөрийн өдрүүдийг уртасган, ЭЗЭНий хүсэл нь Түүний гарт цэцэглэх болно. (Исаиа 53:10 АБ 2004)

¹⁰Тэр ертөнцөд байсан. Ертөнц Түүгээр бий болсон атал, ертөнц Түүнийг таньсангүй. ¹¹Тэр өөрийнхөндөө ирсэн боловч, өөрийнхөн нь Түүнийг хүлээн авсангүй. (Иохан 1:10-11 АБ 2004)

⁵Есүсийн дүү нар нь хүртэл Түүнд итгээгүй байжээ. ⁶Тэгэхэд нь Есүс тэдэнд -Миний цаг хараахан болоогүй. Харин та нарын цаг үргэлж бэлэн байдаг.

⁴⁸Захирагчид болон фарисайчуудаас хэн ч Түүнд итгээгүй биз дээ? (Иохан 7:5/48 АБ 2004)

20.7 Дээгүүр өнгөрөх баярын үеэр алах хуйвалдаан

⁴⁵Мариагийн ирсэн иудейчүүдээс олон хүн Есүсийн хийсэн зүйлийг хараад, Түүнд итгэжээ. ⁴⁶Харин тэдний зарим нь фарисайчууд уруу очиж, Есүсийн хийсэн зүйлийг тэдэнд хэлцгээв. ⁴⁷Тэгтэл ахлах тахилч нар болон фарисайчууд зөвлөлдөж -Бид юу хийх вэ? Энэ хүн олон тэмдгийг үйлдэж байна. ⁴⁸Хэрэв бид Түүнийг ингээд орхивол, бүх хүмүүс Түүнд итгэнэ. Тэгвэл ромчууд ирж, манай орныг болон үндэстнийг маань устгана даа гэцгээв. ⁴⁹Харин тэдний нэг болох тэр жил тэргүүн тахилч болсон Каиаф тэдэнд -Та нар юу ч мэдэхгүй, ⁵⁰мөн бүх үндэстнээрээ мөхөхгүйн тулд ард түмний төлөө нэг хүн үхэх нь дээр гэдгийг ч бодохгүй байна гэж хэлэв. ⁵¹Тэр энэ үгсийг өөрийн санаагаар хэлээгүй. Харин тэр жилийн тэргүүн тахилч байсан учир тэрээр Есүсийн үндэстнийхээ төлөө үхэх тухай болон ⁵²Түүний зөвхөн үндэстнийхээ төлөө бус, харин Бурханы тарсан хүүхдүүдийг бөөгнүүлж нэгтгэхийн төлөө үхэх тухай эш үзүүлжээ. ⁵³Энэ

өдрөөс тэд Есүсийг алахаар төлөвлөв. ⁵⁴Тиймээс Есүс иудейчүүдийн дунд дахиж илээр явсангүй. Харин тэндээс цөлийн ойролцоох нутаг уруу явж, Ефраим гэдэг хотод очжээ. Тэнд шавь нарынхаа хамт үлдэв. ⁵⁵Иудейчүүдийн Дээгүүр Өнгөрөх баяр ойртсон байлаа. Олон хүн өөрсдийгөө ариусгахаар Дээгүүр Өнгөрөх баяраас өмнө нутгаасаа Иерусалим уруу иржээ. ⁵⁶Тэд Есүсийг хайж, сүм дотор байхдаа өөр хоорондоо -Та нар юу гэж бодож байна? Тэр баяр дээр ирэх болов уу? хэмээн ярьж байлаа. ⁵⁷Ахлах тахилч нар болон фарисайчууд хэрэв Түүний хаана байгааг мэдсэн хүн байвал Есүсийг бариулахаар энэ тухай мэдэгдэх ёстой гэсэн зарлиг буулгасан байв. (Иохан 11:45-57 АБ 2004)

20.8 Урвалт

¹⁸Би та нарын бүгдийн чинь тухай яриагүй. Сонгосон нэгнээ Би мэднэ. Харин энэ нь “Миний талхыг идэгч нь Миний эсрэг өсгийгөө өргөв” гэж бичигдсэн Судрыг биелүүлэхийн тулд юм. ¹⁹Үүнийг биелэхээс өмнө Би одооноос та нарт ярьж байна. Энэ нь биелэх үед “Би байдаг” гэдэгт та нарыг итгүүлэхийн тулд билээ. ²⁰Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Миний илгээдэг хэнийг боловч хүлээн авч буй хүн Намайг хүлээн авдаг. Намайг хүлээн авдаг хүн Намайг Илгээгчийг хүлээн авдаг гэж айлдлаа.

²¹Есүс эдгээрийг хэлээд, сүнс нь шаналж эхлэн, гэрчилж - Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Та нарын нэг Намайг барьж өгнө гэлээ. ²²Түүний хэний тухай ярьж буйг мэдэх гэж гайхшран, шавь нар нь бие бие уруугаа харж эхлэв. ²³Түүний шавь нарын нэг болох Есүсийн хайрласан хүн Есүсийн цээжийг налаад сууж байлаа. ²⁴Тэгтэл Симон Петр түүн уруу дохиж, -Түүний хэний тухай хэлж байгааг бидэнд хэлээч гэв. ²⁵Тэр Есүсийн цээжийг налсан хэвээр -Эзэн, тэр хэн юм бэ? гэсэнд

²⁶Есүс -Энэ талхыг Би дүрээд хэнд өгнө, тэр хүн нь мөн гэж айлдаад, талхны хэлтэрхийг дүрж [аваад] Искаротын Симоны хүү Иудаст өгчээ. ²⁷Дараа нь түүнд Сатан шүглэв.

Тэгтэл Есүс Иудаст -Чи хийх гэж байгаа юмаа түргэн хий гэлээ. ²⁸Харин тухлан суугчдын хэн нь ч Есүсийн юуны

улмаас тэгж хэлснийг мэдсэнгүй. ²⁹Зарим нь Иудаг мөнгөний хүүдий байсан тул Есүс түүнд “Баярт зориулан бидэнд хэрэгтэй юмыг худалдан ав” эсвэл, “Ядууст ямар нэгэн юм өг” гэсэн байх гэж боджээ. ³⁰Тэгээд Иудас талхны хэлтэрхийг аваад тэр даруй гарч явлаа. Тэгэхэд шөнө байв. (Иохан 13:18-30 АБ 2004)

20.9 30 мөнгөн зоосоор зарагдсан

¹²Би тэдэнд “Хэрэв энэ нь та нарт сайн гэж үзэгдвэл надад хөлсийг минь өг. Харин, хэрэв үгүй бол боль” гэв. Ингээд тэд миний хөлс гэж гучин мөнгөн шекелийг хэмжив. (Зехариа 11:12 АБ 2004)

¹⁴Тэр үед арван хоёрын нэг болох Искаротын Иудас ахлах тахилч нар уруу очиж, ¹⁵-Түүнийг та нарт тушаавал та нар надад юу өгмөөр байна? гэхэд тэд түүнд гучин мөнгөн зоос дэнслээд өгөв. (Матай 26:14-15 АБ 2004)

20.10 Буруутгагчдынхаа өмнө дуугүй байсан

⁷Тэр тамлагдсан, зовсон боловч амаа нээсэнгүй. Алагдахаар хөтлөгдөх хурга шиг, хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг Тэр амаа нээсэнгүй (Исаиа 53:7 АБ 2004)

¹²Ахлах тахилч нар болон ахлагчид Есүсийг буруутгахад Тэр юу ч хариулсангүй. ¹³Пилат Түүнд -Тэд Таны эсрэг хичнээн олон зүйл гэрчилж байгааг Та сонсохгүй байна уу? гэхэд ¹⁴Тэр түүнд нэг ч үг хэлсэнгүйд захирагч ихэд гайхжээ. (Матай 27:12-14 АБ 2004)

20.11 Бидний нүглийн төлөө

¹Бидний мэдээнд хэн итгэсэн бэ? ЭЗЭНий мутар хэнд илэрхийлэгдсэн бэ? ²Учир нь Тэр Түүний өмнө нялх нахиа мэт, хуурай газраас гарсан үндэс мэт ургасан.Түүнд хэлбэр дүрс, цог жавхлан байхгүй. Бид Түүнийг харья гэсэн ч бидний анхаарлыг татахуйц дүр төрх алга.

³Тэр үзэн ядагдаж, хүмүүсээр орхигдов. Тэр уй гашууны хүн бөгөөд өвчин зовлонг мэдсэн. Бид нүүрээ Түүнээс нуусан.

Тэр үзэн ядагдаж, бид Түүнийг хүндэтгээгүй.⁴ Үнэхээр Тэр бидний өвчнийг Өөртөө тээж, бидний уй гашууг даав. Харин бид Түүнийг Бурханд яллагдаж, цохигдож, зовсон гэж бодов.

⁵Гэвч Тэр бидний нүглийн төлөө хатгагдан, бидний гэмийн төлөө бяцарчээ. Бидний амар амгалангийн төлөө Түүн дээр гэсгээлт бууж, Түүний шархаар бид эдгэрсэн. ⁶Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрийн замаар явав. Харин ЭЗЭН бидний гэмийг бүгдийг нь Түүнд тохов.

⁷Тэр тамлагдсан, зовсон боловч амаа нээсэнгүй. Алагдахаар хөтлөгдөх хурга шиг, хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг Тэр амаа нээсэнгүй. ⁸Хавчлага шүүх Түүнийг аваад явлаа. Хэн Түүний үр удмын тухай бодох вэ? Тэр миний ард түмний нүглийн төлөө цохигдож, амьдын газраас таслагдсан. ⁹Түүний булш нүгэлт хүмүүстэй хамт байх байсан боловч, Тэр үхэлдээ баян хүнтэй хамт байсан. Тэр хүчирхийлэл үйлдээгүй. Түүний аманд нь ямар ч худал хуурмаг байгаагүй.

¹⁰Гэвч Түүнийг няцалж, өвтгөх нь ЭЗЭНий таалал байв. Хэрэв Тэр Өөрийгөө нүглийн төлөөх тахил болгон өргөвөл, Тэр үр удмаа үзэж, Өөрийн өдрүүдийг уртасган, ЭЗЭНий хүсэл нь Түүний гарт цэцэглэх болно. ¹¹Түүний сэтгэлийн шаналлын үр дүнд Тэр харж, сэтгэл нь ханах болно.

Миний Боол, Зөв шударга Нэгэн Өөрийнхөө мэдлэгээр олныг зөвтгөж, тэдний нүглийг нь үүрэх болно. ¹²Ийм учраас Би Түүнд ихэстэй хамт хувь ногдуулна. Тэр олзыг хүчтэнтэй хуваана. Яагаад гэвэл Тэр Өөрийн амийг үхэл уруу асгаж, хилэнцтэнүүдтэй хамт тоологдсон. Гэвч Тэр олны нүглийг Өөртөө тээж, хилэнцтэнүүдийн төлөө зуучлан залбирсан.

[] Үхлийн хүчийг залгиж, Сүмийг худалдан авч, Түүний үхэл болон амилалтад итгэдэг бидэнд Өөрийн (дайснаас дээгүүрх Есүс–эрх мэдлийн хүчирхэг нэр) нэрийг өгсөн.

20.12 Тохуурхагдсан

⁷Намайг хардаг бүхэн намайг тохуурхан инээдэг. Тэд уруулаа нээж, толгой сэгсрэн ⁸“Тэр өөрийгөө ЭЗЭНд даатгасан. Тэр

түүнийг авраг! Тэр түүнд баярладаг тул түүнийг авраг!” гэж байна. (Дуулал 22:7-8 АБ 2004)

³¹Тэд Есүсийг дооглосны дараа Түүнээс нөмрөгийг нь тайлж хувцсыг нь өмсгөв. Тэгээд Түүнийг цовдлохоор авч явлаа. (Матай 27:31 АБ 2004)

20.13 Зодуулсан

¹⁴Түүний төрх нь аливаа хүнийхээс, Түүний хэлбэр нь хүний хөвгүүдийнхээс илүүгээр зэрэмдэг байсан учраас олон хүмүүс чамайг үзээд хирдхийв.

²⁶Тэгээд тэр Барабыг тэдэнд суллан, Есүсийг ташуурдсаны дараа цовдлуулахаар болжээ. (Матай 27:26 АБ 2004)

20.14 Нулимсан

⁶Цохигчдод Би нуруугаа өгч, сахлыг минь үгтээх хүнд Би хацраа тавьж өглөө. (Исаиа 50:6 АБ 2004)

³⁰Түүн уруу нулимж, хулсыг нь аваад толгой уруу нь цохилоо. (Матай 27:30 АБ 2004)

20.15 Түүний хувцсыг шодсон

¹⁸Тэд миний гадуур хувцсыг хоорондоо хувааж, Миний дотуур хувцасны төлөө шоддог. (Дуулал 22:18 АБ 2004)

²³Цэргүүд Есүсийг цовдлоод, гадуур хувцсыг нь авч дөрвөн хэсэг болгож хувь хувиа хүртжээ. Дээрээс нь битүү нэхсэн ямар ч оёдолгүй дотуур хувцас бас байлаа. ²⁴Тэд хоорондоо - Үүнийг урахгүй. Харин хэнийх болохыг шийдэхийн тулд үүний төлөө шодоцгооё гэв. Энэ нь “Тэд гадуур хувцсыг минь хуваан авч, Миний хувцасны төлөө шодох болно” [гэсэн] Судар биелэгдэхийн тулд ажээ. (Иохан 19:23-24 АБ 2004)

20.16 Түүний гар, хөлийг нэвт хатгасан

¹⁶Учир нь намайг ноход хүрээлжээ. Бүлэг хорон санаатнууд намайг бүсэлжээ. Тэд миний гар, хөлийг нэвт хатгасан.
(Дуулал 22:16 АБ 2004)

³¹Тэд Есүсийг дооглосны дараа Түүнээс нөмрөгийг нь тайлж хувцсыг нь өмсгөв. Тэгээд Түүнийг цовдлохоор авч явлаа.
(Матай 27:31 АБ 2004)

20.17 Хулгайч нартай хамт цовдлогдсон

¹²Ийм учраас Би Түүнд ихэстэй хамт хувь ногдуулна. Тэр олзыг хүчтэнтэй хуваана. Яагаад гэвэл Тэр Өөрийн амийг үхэл уруу асгаж, хилэнцтэнүүдтэй хамт тоологдсон. Гэвч Тэр олны нүглийг Өөртөө тээж, хилэнцтэнүүдийн төлөө зуучлан залбирсан. (Исаиа 53: 12 АБ 2004)

³⁸Тэр үед Түүнтэй хамт хоёр дээрэмчин цовдлуулж, нэг нь баруун талд, нөгөө нь зүүн талд байлаа.
(Матай 27:38 АБ 2004)

20.18 Хавчигчдынхаа төлөө залбирсан

³⁴Есүс -Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна гэв. Тэд шодоод, Түүний хувцсыг хуваан авчээ. (Лук 23:34 АБ 2004)

20.19 Түүний хажуу уруу жадалсан

¹⁰Би нигүүлслийн, гуйлтын Сүнсийг Давидын гэр дээр, Иерусалимын оршин суугчид дээр асгана. Тэгснээр тэд өөрсдийн жадалсан Намайг харна. Тэд ганц хүүгийнхээ төлөө гашуудаж буй нэгэн мэт Түүний төлөө гашуудан, ууган хүүгийнхээ хойноос асгартал уйлдаг шиг Түүний хойноос асгартал уйлах болно. (Зехариа 12:10 АБ 2004)

³⁴Цэргүүдийн нэг нь Түүнийг хажуу уруу нь жадлахад цус, ус гоожлоо. (Иохан 19:34 АБ 2004)

20.20 Цөстэй хольсон дарс болон цуу уулгасан

²¹Тэд бас надад миний хүнсэнд цөсийг, Намайг цангахад уулгахаар цууг өгсөн. (Дуулал 69:21 АБ 2004)

³⁴цөстэй хольсон дарсыг Түүнд уулгахаар өгөв. Тэр хэдийгээр амссан ч уухгүй байв. (Матай 27:34 АБ 2004)

³⁶Цэргүүд хүртэл Түүнийг дооглон, дэргэд нь ирээд Түүнд гашуун цуу өгч, (Лук 23:36 АБ 2004)

20.21 Нэг ч яс хугараагүй

²⁰Тэр түүний бүх ясыг хамгаалдаг, Тэднээс нэг нь ч хугараагүй юм. (Дуулал 34:20 АБ 2004)

³²Цэргүүд ирж, Есүстэй хамт цовдлогдсон эхний хүний болон нөгөө хүнийх нь хөлийг хугалав. ³³Харин Есүс уруу ирээд Түүний хэдийн үхсэн байхыг тэд үзээд, хөлийг нь хугалсангүй. ³⁴Цэргүүдийн нэг нь Түүнийг хажуу уруу нь жадлахад цус, ус гоожлоо. ³⁵Харсан хүн нь үүнийг гэрчлэв. Түүний гэрчлэл нь үнэн бөгөөд та нарыг ч мөн итгүүлэхийн тулд үнэн ярьдаг гэдгээ тэр мэднэ. ³⁶Судрын “Түүний нэг ч яс хугалагдахгүй” гэсэн нь биелэгдэхийн тулд эдгээр нь болжээ. (Иохан 19:32-36 АБ 2004)

20.22 Баян хүний булшинд оршуулсан

⁹Түүний булш нүгэлт хүмүүстэй хамт байх байсан боловч, Тэр үхэлдээ баян хүнтэй хамт байсан. Тэр хүчирхийлэл үйлдээгүй. Түүний аманд нь ямар ч худал хуурмаг байгаагүй. (Исаиа 53:9 АБ 2004)

⁵⁷Орой нь Ариматаас Иосеф гэгч нэгэн баян хүн хүрч ирлээ. Тэр мөн өөрөө Есүсийн шавь болсон ажээ. ⁵⁸Энэ хүн Пилатад бараалхаж, Есүсийн цогцсыг гуйхад Пилат өгөхийг тушаав. ⁵⁹Иосеф цогцсыг аваад, цэвэр маалинган даавуунд ороож, ⁶⁰хаданд ухаж хийсэн өөрийнхөө шинэ булшинд

тавьж, бул чулуу өнхрүүлэн булшны амыг таглаад явжээ.
(Матай 27:57-60 АБ 2004)

20.23 Цахиур шиг царайтай ба ичгүүрт орохгүй

⁷Учир нь Эзэн БУРХАН Надад тусалдаг. Тийм учраас Би ичихгүй. Тийм учраас Би нүүрээ цахиур мэт байлгана. Ичгүүрт орохгүй гэдгээ Би мэднэ. (Исаиа 50:7 АБ 2004)

20.24 Миний хоньчинг цохигтун (ИСАИА 53)

⁴Ядарсан хүнд үгээр хэрхэн туслахыг мэдээсэй хэмээн Эзэн БУРХАН Надад шавийн хэл өгсөн. Тэр өглөө бүр намайг сэрээн, шавь мэт сонсохын тулд Тэр Миний чихийг нээнэ.
⁵Эзэн БУРХАН Миний чихийг нээв. Би ч татгалзсангүй, гэдрэг ухарсангүй.

⁶Цохигчдод Би нуруугаа өгч, сахлыг минь үгтээх хүнд Би хацраа тавьж өглөө. Доромжлол, нулималтаас Би нүүрээ халхлаагүй.
⁷Учир нь Эзэн БУРХАН Надад тусалдаг. Тийм учраас Би ичихгүй. Тийм учраас Би нүүрээ цахиур мэт байлгана. Ичгүүрт орохгүй гэдгээ Би мэднэ.

⁸Намайг Зөвтгөгч ойрхон байна. Хэн Надтай тэмцэлдэх вэ? Бид нүүр нүүрээрээ тулъя. Хэн Надтай заргалдах вэ? Тэр хүн Миний дэргэд ирэг. ⁹Үзэгтүн, Эзэн БУРХАН Надад тусалдаг. Хэн Намайг яллах вэ? Үзэгтүн, тэд бүгд хувцас адил хуучирч, хорхойд идүүлнэ. (Исаиа 50:4-9 АБ 2004)

⁴Үнэхээр Тэр бидний өвчнийг Өөртөө тээж, бидний уй гашууг даав. Харин бид Түүнийг Бурханд яллагдаж, цохигдож, зовсон гэж бодов. ⁵Гэвч Тэр бидний нүглийн төлөө хатгагдан, бидний гэмийн төлөө бяцарчээ. Бидний амар амгалангийн төлөө Түүн дээр гэсгээлт бууж, Түүний шархаар бид эдгэрсэн. ⁶Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрийн замаар явав. Харин ЭЗЭН бидний гэмийг бүгдийг нь Түүнд тохов. ⁷Тэр тамлагдсан, зовсон боловч амаа нээсэнгүй. Алагдахаар хөтлөгдөх хурга шиг, хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг Тэр амаа нээсэнгүй. ⁸Хавчлага шүүх Түүнийг аваад явлаа. Хэн Түүний үр удмын тухай бодох вэ? Тэр миний ард түмний нүглийн төлөө цохигдож, амьдын газраас таслагдсан. ⁹Түүний булш нүгэлт хүмүүстэй хамт байх байсан боловч, Тэр үхэлдээ баян хүнтэй

хамт байсан.Тэр хүчирхийлэл үйлдээгүй. Түүний аманд нь ямар ч худал хуурмаг байгаагүй.

¹⁰Гэвч Түүнийг няцалж,өвтгөх нь ЭЗЭНий таалал байв. Хэрэв Тэр Өөрийгөө нүглийн төлөөх тахил болгон өргөвөл,Тэр үр удмаа үзэж, Өөрийн өдрүүдийг уртасган, ЭЗЭНий хүсэл нь Түүний гарт цэцэглэх болно. ¹¹Түүний сэтгэлийн шаналлын үр дүнд Тэр харж, сэтгэл нь ханах болно. Миний Боол, Зөв шударга Нэгэн Өөрийнхөө мэдлэгээр олныг зөвтгөж, тэдний нүглийг нь үүрэх болно.¹²Ийм учраас Би Түүнд ихэстэй хамт хувь ногдуулна.Тэр олзыг хүчтэнтэй хуваана.Яагаад гэвэл Тэр Өөрийн амийг үхэл уруу асгаж, хилэнцтэнүүдтэй хамт тоологдсон. Гэвч Тэр олны нүглийг Өөртөө тээж, хилэнцтэнүүдийн төлөө зуучлан залбирсан. (Исаиа 50:4-13 АБ 2004)

¹Тэгээд Дээгүүр Өнгөрөх баяраас зургаан өдрийн өмнө Есүс Бетанд иржээ. Тэнд Есүсийн үхлээс амилуулсан Лазар байлаа. ²Тэд тэнд Есүст зоог бэлдэж, Марта үйлчилж байв. Харин Есүстэй хамт тухлан сууж байсан хүмүүсийн нэг нь Лазар байв. ³Тэгтэл Мариа маш үнэтэй цэвэр нардын нэг литра үнэрт тос аваад, Есүсийн хөлийг тослож, үсээрээ хөлийг нь арчив. Гэр нь тосны анхилам үнэрээр дүүрлээ. ⁴Харин Есүсийн шавь нарын нэг буюу Түүнийг барьж өгөхийг бодож байсан Искаротын Иудас ⁵-Яагаад энэ тосыг гурван зуун денараар зарж, ядууст өгсөнгүй вэ? гэв. ⁶Тэрээр ядуусын талаар санаа тавьсандаа бус, харин хулгайч байсан болохоор тэгж хэлжээ. Тэр мөнгөний хүүдийг барьж, дотор нь хийснийг нь авчихдаг байжээ. ⁷Тэгтэл Есүс - Түүнийг орхи. Миний оршуулгын өдөрт зориулж Мариа үүнийг хадгалаг. ⁸Учир нь та нар үргэлж ядуустай цуг байна. Харин та нар Надтай үргэлж цуг байхгүй гэж айлдав. ⁹Үй олон иудейчүүд Есүсийг тэнд байгааг мэдээд зөвхөн Есүсийн төлөө биш, харин Түүний үхлээс амилуулсан Лазарыг бас үзэхээр иржээ. ¹⁰Харин ахлах тахилч нар мөн Лазарыг алахаар зөвлөлдөв. ¹¹Учир нь Лазараас болж иудейчүүдээс олон хүн явж, Есүст итгэж байлаа. (Иохан 12:1-11 АБ 2004)

[] Мессиагийн төрөлт ба үхлийн тухай бичсэн эш үзүүлэгийг жагсааж бичиж чадах уу?

[] Есүс Христ энэ бүх эш үзүүлэгийг биелүүлснийг та мэдэх үү?

[] Хэн яагаад таныг эдгээрт итгэхэд саад хийдэг болохыг та мэдэх үү?

[] Та Есүс Христ бол Сударын эш үзүүлэгт гардаг Мессиа гэдэгт итгэдэг үү?